MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 10 сарын 26 өдөр Дугаар 47 Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон
гүйцэтгэгчийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.8 дахь заалт, Нэр дэвшүүлэх хорооны 2026 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн НДХ/2026-03 дугаар дүгнэлт, Сангийн сайдын 2026 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 01/11053 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бат-Ирээдүй овогтой Анарыг 2026 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн Гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалтаар Гүйцэтгэх захирал томилогдох хүртэл хугацаанд Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анарын сарын үндсэн цалинг
төгрөгөөр тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч Д.Нарангэрэлд зөвшөөрсүгэй.

3. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулах "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 46 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан гэрээний загварын дагуу байгуулах ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ж.Золбаярт даалгасугай.

4. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч томилогдсонтой холбогдуулан 2026 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн дотор ажил хүлээлцэх акт үйлдэн, ажил хүлээлцэхэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитор Г.Байгалд үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Ж.Золзаяа)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.БАТ-ЭРДЭНЭ

Монголын Хөрөнгийн Бирж
УХА 0163
ТУЗ

15[illegible]140